

Федеральное государственное  
бюджетное учреждение науки  
Институт монголоведения, буддологии  
и тибетологии Сибирского отделения  
Российской академии наук

# КУЛЬТУРА ЦЕНТРАЛЬНОЙ АЗИИ

*письменные  
источники*

**Выпуск 13**

Улан-Удэ  
Издательство БНЦ СО РАН  
2020

УДК 930  
ББК 63.2+86.39(5А/Я)  
К 906

**Редакционная коллегия:**

д-р ист. наук, проф. *Ц. П. Ванчикова* (отв. редактор),  
д-р ист. наук *С. В. Бураева*, канд. филол. наук *Д. В. Дашибалова*,  
канд. ист. наук *М. В. Аюшеева* (секретарь)

**Рецензенты:**

д-р культурологии, проф. *М. И. Гомбоева*  
канд. ист. наук *Б. Д. Цыбенков*  
канд. филол. наук, доц. *О. Д. Тугулова*

**К 906** **Культура Центральной Азии: письменные источники.**  
**Вып. 13.** – Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2020. – 156 с.

Предлагаемый вниманию читателей очередной выпуск серии «Культура Центральной Азии: письменные источники» состоит из трех блоков. В первом, посвященном философии и истории буддизма, продолжают исследования текста «Ратна-гуна-самчягатха», дополненные переводом XXVI–XXXII глав; представлены результаты изучения специфики тибетской исторической литературы жанра чойчжун, а также классификация личностных качеств у обучающихся медицине, согласно тибетским источникам. Во втором блоке раскрыты стилевые особенности исторических новелл Б. Ринчена и публикуются сведения об организации научной библиотеки Бурятского ученого комитета. Третий содержит статьи по источниковедению, архивоведению и кодикологии документальных, фото и книжных коллекций.

Представляет интерес для специалистов и широкого круга читателей, интересующихся вопросами истории и культуры народов Центральной Азии.

УДК 930  
ББК 63.2+86.39(5А/Я)

ISSN 2304-1838

© ИМБТ СО РАН, 2020  
© Коллектив авторов, 2020  
© Изд-во БНЦ СО РАН, 2020

DOI 10.30792/2304-1838-2020-13-46-68

УДК 243

ББК 86.35

*Г. Мягмарсүрэн*

#### ПАГБА-ЛАМА ЛОДОЙЖАНЦАН И ЕГО ПОУЧЕНИЯ

Большое влияние на монгольскую культуру, общество, мировоззрение оказал буддизм. Особенно после приглашения ко двору монгольских императоров в период династии Юань тибетских учителей Сакья-пандиты Гунгажанцана и Пагба-ламы Лодойжанцана были установлены тесные тибето-монгольские отношения. В тот период была разработана концепция двух ветвей власти: светской и духовной. Пагба-лама составил множество произведений, адресованных монгольской знати, императорским сыновьям с разъяснением буддийского учения. В настоящей статье рассмотрено творчество Пагба-ламы, выдающегося буддийского деятеля, который продолжительное время находился в Монголии, и является автором трехтомного сумбума – собрания сочинений. Среди его работ около 30 – посвящены Монголии и могут быть подразделены на 4 группы: благопожелания о благоденствии, благопожелания о благодеяниях, послания, поучения о религии и государстве.

*Ключевые слова:* история буддизма, тибето-монгольские отношения, Пагба-лама Лодойжанцан, поучения, Юань

*Myagmarsuren Gombodorj*

#### PAGBA LAMA LODOIZHALTSAN AND HIS TEACHINGS

The spreading of Buddhism has implanted a profound effect on the social, political and ideological culture and tradition of the Mongolian. A vivid example of this can be seen in the relationship between the Tibetan monks such as Lama Pagba and the Mongol princes of the Yuan Dynasty. For example, Lama Pagba wrote numerous literary works on the basis of Buddhist teachings and sent them to the rulers of the Yuan Dynasty, such as Chingim, the prince, Mangal, Zevegtumur, Nomugan and Tumurbukh. The purpose of this article is to analyze these sources.

*Key words:* history of Buddhism, Tibeto-Mongolian relations, Pagbala Lodoizhantsan, didactic poem, Yuan

ПАГВА ЛАМААС ИХ МОНГОЛЫН ЮАНЬ ГҮРНИЙ ХАН  
ХӨВГҮҮДЭД ЗОРИУЛСАН ХОС ЁСНЫ СУРГААЛИЙН  
ТУХАЙ

Бурхны шашин дэлгэрсэнээр монгол үндэстний нийгэм, улс төр, үзэл бодлын соёл уламжлалд маш их нөлөө үзүүлсэн юм. Ялангуяа их Монгол оронд XIII зууны үеэс уригдаж залагдаж байсан Төвдийн Саж бандид Гунгаажанцан (1182–1251), Пагва лам Лодойжанцан (1235–1280) тэргүүтэн «номын багш» нар төр, шашны хос ёсны үүднээс заан номлосон онол сургаал нь хаан төрийг номын үүднээс удирдан тэтгэх, төр шашныг хослон хөгжүүлэх тухай эртний Энэтхэгээс улбаатай онол сургаал юм. Доктор, профессор Л. Хүрэлбаатарын бичсэнчлэн «XIII зууны дундуураас Монголчууд Энэтхэгийн бурхны шашныг Төвдөөр дамжуулан авах явцад Төвд, Монголын харилцаанд ном соёлын давхар хэлхээ тогтож, Төвд орон Монголчуудын оюун санааны амьдралын гол чухал төв болж байв» [Хүрэлбаатар, 1987] гэжээ.

Үүний нэгэн тод жишээ нь Юань гүрний их хаад, хан хөвгүүд, хатад ба төвдийн Пагва лам нарын харилцаанаас харж болно. Энэ өгүүлэлд бид Пагва ламын монголчуудтай холбоотой зохиол бүтээлээс тухайлан сургаалийн шүлэг зохиолын тухай өгүүлэхийг зорьлоо. Монголын түүхэн сурвалж бичгүүдэд тэмдэглэсэнээр Мадидуаз хэмээх Пагва лам Лодойжанцан нь арван настайдаа монгол газар ирснээс хойш нас эцэслэх хүртэл буюу 35 жилийн турш монголчуудтай холбоотой байж, түүний намтарт өгүүлснээр амьдралынхаа бараг ихэнх хугацааг монгол нутагт өнгөрөөсөн байдаг. Пагва лам бурхны шашны онол номлол, магтаал, залбирал, бясалгал, уншлага, бүтээлийн арга зэрэг зохиолуудаас бүрдэх нийт гурван боть сүмбүм зохиол туурвисан байна.

Бидний олж үзсэнээр Пагва ламын зохиосон монголчуудтай холбоотой гуч илүү зохиол нь түүний сүмбүмд оржээ. Эдгээрийг амар амгалан өлзий хутаг өгүүлэх шүлэглэл, ном судар бүтээсний буяны зориулга ерөөл, захиа бичиг, төр, шашны сургаал гэсэн дөрвөн зүйлд хувааж авч үзэж болохоор байна. Эдгээрийг тодорхойлон товчхон авч үзье.

### **Өлзий хутгийн шүлэглэл**

Хувилай хаан, хатад, хан хөвгүүдэд 1254 оны хөх бар жилээс 1280 оны цагаан луу жил хүртэл буюу өөрийн нирваан болтол Пагва лам жил бүрийн цагаан сараар өлзий хутаг ерөөсөн шүлэг тусгайлан зохион илгээж байсан байна. Түүний сүмбүмд<sup>1</sup> нийт 23 жилийн хаанд өргөсөн «сар шинийн мэндчилгээ» байна. Харин энэ дунд 1259 оны шарагчин хонь, 1260 оны цагаан бич хоёр жилийнх сүмбүмд ороогүй харагдах бөгөөд чухам ямар шалтгаанаар эдгээр хоёр жилийн мэндчилгээ орхигдсон шалтгааныг энэхэн зуур тодруулж эс чадав. Бусад өлзий өгүүлэх шүлэглэлийн хувьд гэвэл Мангал<sup>2</sup> эцэг эхэд соёрхсон өлзий хутаг өгүүлэх «Нэгнээ туслах» хэмээх [Мангал эцэг эхэд соёрхсон... : 314–315] нийт 12 мөр бадаг шүлгийн эхний гурван бадгийг нэг, хоёр, гурвын тоогоор буюу тухайлбал «нэгнээ туслах», «нэг садан», «нэг шүхэр», «нэг өлзий», «хоёр чуулган», «хоёр үнэн», «хоёр тус», «хоёргүй зарлиг», «гурван лагшин», «гурван хөлгөн», «гурван сансар», «гурван цаг» гэж тоогоор магадлах чимгийн үүднээс шүлэглэсэн бол, Зэвэгтөмөр<sup>3</sup> хан хөвгүүнд соёрхсон өлзий хутгийн шүлэгт [Зэвэгтөмөр хан хөвгүүнд соёрхсон... : 315–316] хамгийг айлдах эрдмийн дэлбээ машид дэлгэрч, яруу алдрын сайн үнэр анхилсан, бадам цэцэг мэт бурхны, амссан төдийд дээд амгаланг өгөгч, сайн зарлигийн

---

<sup>1</sup> 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 600–635.

<sup>2</sup> Хубилай хааны гутгаар хөвгүүн, Чинь ван 秦王, Ань Си ван 安西王 цолтой. 1280 оны орчимд нас баржээ.

<sup>3</sup> Зэвэгтөмөр нь Годан ноёны гутгаар хөвгүүн юм.

рашааны шимт дээдийн номын, сайн номлолын оюуны хүч төгс, ариун номын дууг дуурсгагч, буян билгүүний чуулганы хос далавч төгөлдөр хуврагийн адистид ба эдгээр гурван эрдэнийн буян гарахын орон, олон эрдмийн хүй сан багшийн адис жанлаваар өлзий хутаг оршихыг бэлгэдэн ерөөжээ.

### **Зориулга ерөөл**

Бурхан шүтээн бүтээсэн, ном судар хэвлэн түгээсэн зэрэг өглөгийн эздийн үйлдсэн аливаа буяны зориулга ерөөлийг ихэс лам нараас тусгайлан зохиох уламжлал Төвд, Монголд нэлээд түгээмэл харагддаг. Пагва лам «Хубилай хаан Дэлгэрэнгүй, дунд, хураангуй судар бүтээсний буяны бэлгэдэл»<sup>1</sup>, «Мангал эцэг, эх сэлт дэлгэрэнгүй, дунд, хураангуй ба Олонх судар бүтээсний буяны бэлгэдэл»<sup>2</sup>, «Зэвэгтөмөр хан хөвгүүн Олонх, Алтангэрэл, Зуун мянгат сэлт судар бүтээсний буяны бэлгэдэл»<sup>3</sup>, «Арагч<sup>4</sup> хаан Буман шүлэгт судар бүтээсний буяны бэлгэдэл»<sup>5</sup> зэрэг их хөлгөн судрыг цэвэр алтаар бүтээн барласан буяны зориулга ерөөлийг зохиожээ.

---

<sup>1</sup> go pe las rgyas 'bring bsdus gsum bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 461–464. Хөхөгчин гахай жилийн долдугаар сарын арван тавны өдөр Зомдо найсар гэдэг газар бичив гэжээ.

<sup>2</sup> mang ga la yab yum gyis rgyas 'bring bsdus gsum dang phal po che bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 449–453. Хөхөгчин гахай жилийн найман сарын шинийн найманд Зомдо найсар гэх газар зохиожээ.

<sup>3</sup> ji big de mur gyis phal chen gser 'od stong phrag brgya pa mams bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 454–459. Харагчин тахиа жилийн хаврын дунд сард Ярмо тангийн Шингүн гэдэг газар зохиожээ.

<sup>4</sup> Дөрвөн аймгийн Дөрөвчин хатнаас мэндэлсэн Хубилай хааны 7-р хөвгүүн. Си Пин ван 西平王 цолтойгоор Төвдийг захирч байв.

<sup>5</sup> a rog ches (rgyal po al go cha) 'bum bzhengs pa'i rab byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 459–461. Хөх нохой жилийн намрын гуравдугаар сарын арван гуравны өдөр бичив гэжээ.

## **Захиа бичиг**

«Захидал бичиг нь дорно, өрнийн эртний уран зохиолд бараг бүтэн төрөл зүйл болон хөгжиж ирсэн уран зохиолын сонин дурсгал» [Хүрэлбаатар, 2002: 453] бөгөөд ер «захиа бичгийг гүн ухаан, түүх, уран зохиолын нийлэг шинжтэй бүтээл» [Мөн тэнд: 453] гэж тодорхойлдог байна. Монголчуудын Чингим<sup>1</sup>, Зэвэгтөмөр, Хөхэчи<sup>2</sup> зэрэг хан хөвгүүд, Дугалдүрми (?) зэрэг хатдад Пагва лам тусгайлан зохист аялгууны чимгээр чимэглэн шүлэглэсэн уран яруу хэллэгтэй захидал бичиг илгээж байсан байна. Тодруулбал, хан хөвгүүн Чингимд хулгана, үхэр, гахай жил, Төвдийн Сажа хийд, Хатан гол, Драда нэрт газраас илгээсэн хийгээд мөн он, газар тодорхойгүй зэрэг нийт дөрвөн захидал, Зэвэгтөмөр хан хөвгүүнд луу, хар бич жилийн цагаан сараар болон бусад он, газар нь тодорхойгүй нийт таван захидал, Дугалдүрми хатанд илгээсэн хоёр зүйл захидал бичиг зэргийг бичин өргөсөн нь түүний сүмбүмд оржээ. Эдгээр захидал бичгүүд нь амар мэнд асууж айлтгасан, амар амгалан, өлзий хутаг хүсэн ерөөсөн утга агуулга зонхилж байна.

## **Төр, шашны сургаал**

Академич Д. Цэрэнсодном багш «Эртний Энэтхэг, Төвдөөс уламжлалтай хос ёсны сургаалийн шүлэг зохиол XIII зууны үеэс уламжлан ирсэн» [Цэрэнсодном, 1997: 332] гээд «сургаалийн шүлэг нь Бурхны шашны уншлага, ерөөл, магтаал тэргүүтнээс сэдвийн хувьд өргөн, үг хэл уран бөгөөд баялаг, аливаа сайн муу явдлыг хүнд танин мэдүүлэхийн хувьд сурган хүмүүжүүлэх, гэгээрүүлэх олон талын ач холбогдолтой» [Мөн тэнд: 334] гэж сургаалийн уран зохиолыг тодорхойлсон байдаг.

Саж бандид тэргүүтэн Төвдийн шашин номын зүтгэлтнүүдээс эхлээд Монголын шашин номын хүмүүс «хоёр ёс» буюу хаан төр ба шашин хоёрын тухай эртний Энэтхэгийн

---

<sup>1</sup> Чингим (1243–1286) Хубилай хааны дэд хөвгүүн.

<sup>2</sup> Хөхэчи (?–1271) нь Хубилай хааны 5 дугаар хөвгүүн.

Бурхны шашны онол сургаалийг Монголын хаадын төрийн бодлого, үзэл баримтлалд хэрэглэх болов уу хэмээн үзэж, цаашлаад хос ёсны үүднээс иргэн ардыг хүмүүжүүлэх зорилготой олон сургаалийг бичиж [Хүрэлбаатар, 2002: 19] үлдээжээ.

Академич Ц. Дамдинсүрэн «төвд хэлт утга зохиолд байгаа иргэний уран зохиолыг ерөнхийд нь дөрвөн урсгалд хуваан хэлэлцэж болно» гээд түүний нэгэнд хос ёсны сургаалийг оруулан үзсэн байдаг.

Хос ёсны сургаалийн талаар доктор, профессор Л. Хүрэлбаатар бичихдээ «... шашны үзэл онолыг жирийн олонд ойлгомжтойгоор номлох, ертөнцийн эгэл ардыг шашны номын зүг алгуураар хандуулах зорилгын үүднээс «хос ёс», «ертөнц хийгээд номын ёс» гэдгийг ихэд өргөж, тусгайлан тайлбарласан» гээд «... «хос ёс» гэдгээр дамжуулж, жирийн олныг номын ёсоор хөтлөх», «номын ёс» гэдэгт хүргэх эчнээ зорилгын үүднээс «ертөнцийн ёс» буюу «төрийн ёс»-ыг тайлан сургах явдал юм. Өөрөөр хэлбэл төрийн тохитой хүнээр дамжуулан, шашны ёсыг дэлгэрүүлэх аргыг урьдал болгон авсан байна», «...Төвдийн Бурхны шашны зүтгэлтнүүд Монголчуудын оюун санааг шашин номоор засан сайжруулахад тэдэнд эхлээд энэ насны амьдралаас уйдан залхаж, хойт мөрийг бясалгах шашны номлолыг тулган хүлээлгэх биш, харин ертөнцөд зөв сайхан аж төрөх утгатай сургаалийг эн түрүүнд хүргэх зорилго тавьж байв» гэжээ.

Саж бандид Гунгаажанцан өөрийн бага ач Пагва, Чагнаа (1239–1267) хоёрыг дагуулж, Монголын хаанд залагдаж очсон хойноо Төвдийн Үй, Зан, Арийн хар шар олонд илгээсэн нэгэн захианд бичихдээ «... эдүгээ ... Пагва төвд номыг үзэж байна. Чагнаадорж монгол үсэг, монгол хэлийг сурч байна. Би хүний ертөнцийн номоор тэтгэж байна. Та нар Бурхны номоор тэтгэвээс Шагжмунийн шашин гадаад далайн чанад хязгаараас наашид түгэж үл чадах мөн буюу гэж зарлигласан...» [Зава



Дамдин: 92v6–93r4] гэжээ. Үүнээс үзвэл Саж бандид Монголд байхдаа шашны номыг бус хүний буюу иргэний сургаал номлолыг монголчуудад зориулан сургаж байсан байна. Үүний учир нь Бурхны шашны сургаалийг шууд эхэлбэл тэд хүлээж авахгүй, харин ертөнцийн ёсны сургаалийг илүүд үзэж байсан тул хэрэглэн хүсэгч хүмүүсийн байдалд тохируулж, ертөнцийн номоор тэтгэвэл алгуураар Бурхны шашныг «гадаад далайн чанад хязгаараас нааш түгээж чадна» гэж үзсэн байна. Харин түүнийг залгамжилж, Пагва лам зэрэг бусад нь бурхны онол сургаалийг утга агуулга, эрэмбэ дараалалаар нь нэгтгэн бүлэглэж, ухаж ойлгоход хялбаршуулан номлож байв гэж хэлж болохоор байна.

Пагва ламын зохиосон «Хаанд увдислах маш ялгагч» [Хаанд увдислах маш ялгагч: 122–129] хэмээх сурвалж нь анхааран авагдахуун бурхны зарлигийн утгыг мөрийн суурь ариун шагшаабад, мөрийн өмнө үүсгэх өдүүлбэр сэтгэл, мөрийн бодит суурь тэгш агуулах егүзэр бясалгал, мөрийн эрдэм арвитгах арга гэсэн гол номлолын үндсэн бүлэгтэй. Эхний бүлгийг тус тус гэтэлгэгч санваар, бодьсадвын сэтгэл үүсгэх, сахил эс сахихын гэм алдаа, санваар сахьсан тус эрдэм, арвис тарни баригчийн сахил санваар гэж хуваагаад, түүнээ сахил хэрхэн авах ёс, хэрхэн сахих ёс, сахьсны тус эрдэм гэж нарийсгаж тайлбарлажээ. Түүнчлэн хоёрдугаар мөрийн өмнө өдүүлбэр сэтгэл үүсгэхийг шалтгаан сэлт ба ямар мэт бясалгах сүсэг, зоригдлын утганд найруулах нигүүлсэх зэргээр номлосон бол гуравдугаар бодьтой тэгш агуулах егүзэрт зоригдол сэлтийг бясалгах, орчлон, нирвааны үндэс сэтгэл хэмээн үзүүлэх зэргээр хувааж тайлбарлажээ. Ер үндсэн, дэд бүлэг бүр эхлээд дэлгэрэнгүй номлоод, төгсгөлд утга агуулгыг хураангуйлсан байдалтай бичжээ.

«Зэвэгтөмөр хан хөвгүүнд увдислан үйлдсэн чандмань эрих» [Зэвэгтөмөр хан хөвгүүнд увдислан...: 143–146] нэртэй

томоохон сургаал Пагва лам улаан бар жил (1266) Сажава их хийдэд зохиожээ. Нийт 204 бадаг шүлгээс бүрдэнэ.

«Энгүй буяны далайгаас мэндэлсэн

Их билиг билгүүнт лагшинтай

Эрдэм цаглашгүйгээр чимсэн

Их Сүмбэр уул мэт хаанд мөргөмү.

Өргөн далай мэт буянаар мэндэлсэн

Өндөр язгуур, баялаг, сүр жавхлан төгс

Өөрийн хан төрийг машид тэтгэхийн цогт

Өв тэгш эрдэнэ мэт ханхүү ялах болтугай»[Мөн тэнд: 143] гэж тахил өгүүлэхээр эхлээд, ертөнцийн авах, огоорох явдал ёсыг номлоод, бага хөлгөний номын ёс, цаашлаад зургаан барамид ба арван газар тэргүүтэн бодьсадвын онол сургаалийг дэлгэрэнгүй шүлэглэн номложээ.

«Өлзий сэтгэлд зохист цогт лагшин эрхшээсэн

Өлзий хорилтгүй хотолд орох зарлигт

Өлзий айдал, энэрэлээр цэнгэгч таалалт

Өлзий хотол чуулган бурхан цогтод мөргөмү.

Орь залуу бодьсадва өлзий алдар төгөлдөр

Онцлон дурдсан тул ялгуусны сайн зарлиг

Онцгой эш, ухаанаар тийн шинжлээд

Огоот өлзий хутагт арвитган өргөсүгэй»[ Мангал хан хөвгүүнд...: 163]

хэмээн эхлэх «Мангал хан хөвгүүнд увдислан үйлдсэн өлзий эрих» нэртэй Пагва ламын зохиосон нэгэн сургаал бий. Санскритаар «мангала», төвдөөр «даш», монголоор «өлзий» хэмээх алдар төгөлдөр хан хөвгүүнд зориулсан тус сургаалийг Пагва улаан хулгана жилийн намрын эхэн сарын шинийн нэгний Бүс одтой өдөр төвдийн Хам газар зохиожээ. Тус сургаал нь бурхны шашны онол сургаал ёсоор илт өндөр ба магад сайн хутаг буюу энэ насны өвчингүй, өндөр нас, эд баялаг, эрх хүчний хотол чуулган бүтээх, хойт нас улмаар төгс гэгээрсэн бурхны хутаг бүтээх сургаал номлолыг товчоолон, утга гүн

бөгөөд агуулга өргөн, олон номлолыг хамруулан шүлэглэжээ.

Тус сургаалд:

«Эдүгээ таны энэ мэт олсон өндөр язгуур ба  
Эрх цог, эд баялаг хотол чуулган аль бүхэн нь  
Өөрийн эрхээр авч залран ирсэн бус бөгөөд  
Өөр бусад урьд үүсгэснээс үүдсэн мөн болой.  
Үлэмж дээд тэнгэр, хишиг буян хэмээх алдаршсан  
Үйлдэгч нэгэн үйлдсэн бус, мөнх хэмээх ба  
Үйлдэгч лүгээ харшлах бөгөөд ертөнцийн үйл  
Үзтэл даган гарах нь үзэгдэхийн тул болой.  
Ертөнцийн олонх жаргал, зовлон нь тиймийн тул  
Ер үйлээс гарму хэмээн бурхан айлдсан бөгөөд  
Ухаанаар шинжлэвч түүнийг бүтээн чадах тул  
Улмаар жаргалыг үүсгэх буяны үйлд бишрэгтүн» [Мөн тэнд: 135–

136]

гэх буюу

«...Эрхэм язгуур, дүрс, билиг ухаан, эд эдлэл  
Эрх баялаг, өвчин үгүй, урт нас сэлтийг  
Өндөр язгуурын долоон эрдэм хэмээн бурхан  
Өдгөө номлосон мэт тэдгээрийг машид тэтгэгтүн.  
Угсаа язгуур гайхамшигтай та мэндэлсэн хэдий ч  
Улмаар буянт явдал үйлсээр буяныг эс үйлдэн  
Омтгой явбаас язгуурын үйл доройтму хэмээн  
Олон судар шасдирт олонтой номлосон тул  
Аливаа ертөнцийн буян явдал үйл хэмээгч нь  
Архи үл уух ба амьдрал ариун ба  
Үргэлж бусдад үл хорлох, тахих зохистыг тахих  
Үтэл дордосыг өглөгөөр даган тэтгэх хэмээн  
Нагаржуна хутагт гэгээн айлдсан ба  
Найзгай ичгүүр, сонжуурыг сайтар хориглож  
Магад бүгдээр муушаах үйлээс няцах хийгээд  
Магтууштай явдал үйлд машид шамдтугай» [Мөн тэнд: 136]

гээд мөн

«... Өөрт хэрэгтэй зарим шасдирыг тэрчлэн  
Өдөр нэжгээдэд нэжгээд үг тогтоовоос  
Үлгэрлэвэл шоргоолжний үлийт ба бал мэт

Өнө удалгүй мэргэн болох хэмээн  
Их бодьсадвын зарлигт гарсан тул  
Энэ мэт ёсоор барих ба сонсох  
Магад шинжлэлээр нягтлан сайтар үзээд  
Машид айлдлыг шинэ сар мэт арвитган зохио» [Мөн тэнд: 138]  
«... Өчүүхэн зөгий бал хураах мэт  
Өөрийн их шамдан чухалчлан хураасныг  
Өөрөө ч эдлэлгүй бусдад булаагдах буй тул  
Өөр бусдын үгүйрлийг бүтээгч нь эдлэл мөн» [Мөн тэнд: 138]  
«... Огоот бадам цэцэгс дэлгэрсэн нууранд  
Олон галуудын сүрэг хөөвч хурах мэт  
Төрөл садан ойр тойронд хорлолгүй баялагт бөгөөс  
Төрөлхтөн бүхэн галуун сүрэг мэт хурах болму» [Мөн тэнд: 140]  
«... Өвдөж зовсонд эм ба идээ хоол  
Өмсөх хувцас, амьдрах хэрэглэл  
Арвис тарни сэлт аль туслах зүйлсээр  
Асран тэтгэх сэлтээр туслан зохиогтун.  
Оточ Манал ба ертөнцийн эрх баялаг  
Охин тэнгэр Аглаг даяанч, Навчит сэлт  
Егүзэр бясалгал, тарни уншлага тэргүүтэнд  
Ер улс хотлоор шамдуулан зохиогтун» [Мөн тэнд: 141]  
«... Алины эрхээр элдэв өвчин үүсгэгч  
Адайр шимнус, мах идэштэн, бүднарыг  
Амарлиулахын тул тахил өглөг үйлдэх  
Аль сайныг үйлдэх зарлиг буулган зохио.  
Аливаа тэдгээр ч бие амар бөгөөс  
Албат харьяат иргэд амьтан бүхэн ч  
Асрахын хүчээр албат төр ямарчлан  
Ашид өвчин, хорлолгүй, амгалан оршму.  
Урт наслах бөгөөс өөр ба бусдын тус  
Улмаар бүгд бүтэх бөгөөд амар амгалан  
Удаан орших аваас номын утга эрэлхийлэх  
Учир буй тул нас уртсах аргыг үйлдэгтүн.  
Эм ба даян бясалгал, нууц тарни тэргүүтэн  
Эдгээр бүхэн насны тотгор арилгах хийгээд  
Нас уртасгагч хэмээн айлдсан тэдгээр бүхнийг

Нандигнан шамдаж бүтээн соёрхогтун.  
Аюулт үхлийн амь хуурах засал ба  
Амьтанд амьны аюулгүйн өглөг  
Аливаа бусад амь таслах үйлийг тэвчвээс  
Адбиш насны цог дэлгэрэх болму.  
Тийн ялгуусан ба Цаглашгүй наст бурхны  
Тогтоол тарни урин уншихад шамдаж  
Олноо өргөгдсөн сэлтийг ойр шүтсэнээр  
Онц нас сүүдэр уртатган зохиогтун.  
Өмнийн буянт үйл, ерөөлийн хүчээр  
Өндөр язгуурт долоон цог олсон та  
Энэ мэт айлтгасан арга ёс үүгээр  
Эдгээрийг дэлгэрүүлэгтүн.

Илт өндөр хэмээх нь энэ буюу» [Мөн тэнд: 141]

хэмээн илт өндөр буюу ирээдүйд тэнгэр, хүн сэлт сайн төрлийг олох буяны үр цогцлоохын тул сайн явдал мөрөөр явах, зөв бодол ухамсар, зөв үйл амьдрал төлөвшүүлэх сургаал айлджээ.

Түүнээс залгуулан

«Тэр мэт ертөнцийн эрх цогт тэрээр  
Тэрчлэн ертөнцөд хотол чуулган болоод  
Ертөнцөөс хэтэрсэн цогоор өөр, бусад бүхнийг  
Ер барилдуулахын тул номын мөр шүттүгэй.  
Ном тэр ч өгүүлэхүүн гурван суртахуун ба

Ногтой үгсийг хиргүй бүтээгч гурав лугаа төгөлдөр» [Мөн тэнд: 142]

хэмээн винай, авидарма, судрын гурван аймаг сав, түүнээс гарах шагшаабад, даян, билиг ухааны гурван суртахуунд суралцах хэрэгтэй гэж товчоор сургаад, түүнээ задлан дэлгэрүүлж номложээ.

«... Хуран үүдсэн хамаг мөнх бус ба  
Хамаг юмс би үгүй, цувирал сэлт зовлонт  
Гаслангаас нөгцвөөс амгалан мөн хэмээх  
Гайхамшигт дөрвөн мутарлагийн зарлиг соёрхов.  
Эдгээр нь Чадагчийн эрхэт бурхны өөрийн нөхцлөөс  
Эрхэм "зарлиг" хэмээн гарсан тэдгээрийг өгүүлмү.

Аливаа бурхны айлдсан зарлиг ямагт тэдгээрт  
Ашид үл алгасрах сэтгэлээр сүсэглэгтүн.  
Дээд нирвааны мөр лүгээ даган барилдаж  
Дээдсийн тааллыг тайлбарласан нь "шасдир"  
Эдгээр нь "эшийн ном" мөн. Түүнийг бясалгаснаар  
Эрхэм онол үлэмж болсон "онолын ном" мөн» [Мөн тэнд: 142]

ГЭЭД МӨН

«... Эдгээр номыг шинжлэн үйлдэх бусдад  
Эгэл бодгаль, үг, шударга утга ба тийн мэдэл  
Нэрийн утга, номын утга, магад утга ба  
Билгүүнд итгэх сэлт дөрвөн итгэл айлдсан тул  
Хоёрдугаарт гурвын тийн шинжлэлээр  
Дөрөвт итгэх ба дөрвөн ёсонд орсонор  
Олж үйлдэх таван ном зэргэчлэн

Ологдохуун тэдгээр нь "магад сайн" ном мөн» гэж цааш нь магад сайн буюу төгс гэгээрлийн хутаг олох арга замын дэлгэрэнгүй номлолыг маш хураангуйлан номложээ. Үүнд ном үйлдэх чөлөөгүй найман орноос гэтлэхийн тул сэтгэл тачаангуй, уур, мунхагийн эрхээр өдөөгдөж, арван хар нүглийг тэвчин, арван учрал төгс хүний биеийг олсны хэргийг үйлдэхийн тул тачаах, уурлах, мунхрах үгүй сэтгэлээр арван цагаан буянд шамдах хэрэгтэй хэмээн [Мөн тэнд: 142–143] сургажээ.

«... Өөр бас үсэгт бичих ба тахих  
Өглөг, сонсох, унших, барих хийгээд  
Номлох, сэтгэх, бясалгах тэргүүтэн  
Номт арван явдлыг аль чадахаар үйлдэгтүн» [Мөн тэнд: 143]  
Түүнээс итгэлийн тухай:

«... Их хөлгөний рашааны үүд нь итгэл хэмээн  
Илт туулсан бурхан айлдсан хийгээд  
Орчлон, муу заяанаас өөр, бусдыг аврахын тул  
Орны шүтээнд сүсэглэх тэр мэт үйлдэхийн тул  
Авралын эрхэм хутаг олох хүртэл  
Авран зүгт орших хамаг бурхад ба  
Их хөлгөний дээдийн хамаг ном  
Илт хутагтан хуврагийг авралд барьж  
Аврал бусыг авралд үл барих ба

Аугаа дээд төрөлхтөн лүгээ нөхөрлөх  
Түүнээс дээдийн ном сонсох хийгээд  
Түүнчлэн ном ёсоор бүтээхэд шамдагтун.  
Их нигүүлсэхийн шалтгаанаас гарсан  
Илт үнэн мэдлийн эрхээр үйлдэгч  
Бодол хүсэл, туурвил ихийн мөн чанарт  
Бодь дээд сэтгэлийг дахин дахин үүсгэж  
«Огторгуйн зүрхэн» судар тэргүүтнээс  
Онцлон ямар мэт айлдсан сургаалыг  
Айлдан түүнээ суралцан зохиогтун.  
Аль номлосон тус эрдмийг хурдан олох болму.  
Үтэл орчлонгийн зовлон тэсэшгүй өвчин мэт нь  
Үйл ба нисваанис бүхэн гарах нь өвчний шалтгаан  
Өвчин үгүй амгалан орших нь хорихуй мөр бөгөөд  
Өндөр мөр нь анагаах эм адил хэмээн айлдан мэдээд  
Тааллаас гаргах ба бүхнээс тэвчих хийгээд  
Таалан дурших ба бүтээхэд шамдах зохиогтун.  
Эдгээрийг хутагтын дөрвөн үнэн хэмээн номлов  
Энэ нь ном бүхний товчлол мөн болой.  
Үүнээс төрөх, өтлөх, өвдөх, үхэх нь  
Үлэмж зовлонгийн дөрвөн далай мөн.  
Хураасны эцэст барагдах, өндрийн эцэст буурах  
Хурсны эцэст хагацах, амьдын эцэст үхэх нь  
Орчлонгийн дөрвөн эцэс хэмээн номлосон» [Мөн тэнд: 144]

гэх зэргээр орчлонгийн мөн чанарыг номлоод, залгуулан  
орчлонг үүсгэгч арван хоёр шүтэн барилдлагыг нэг нь нэгнээс  
үүдэн гарах жам ёсыг айлджээ. Түүнээс:

«... Эш, онолын номд эрхшээн үйлдээд  
Эргүү тачаал тэргүүтэн нирвааны мөрд түйтгэрлэгч  
Зүйл гурван атхагаар хамгийг айлдагчид тогторлогч  
Зүдэг түйтгэр тус тусын ерөндөг ба

Мөрийн дээд эрдэм лүгээ урвуулан зохиогтун» [Мөн тэнд: 145]

гээд түүнээс чухаг гурван эрдэнэ, хутагтын долоон эдлэл,  
зургаан билиг барамид, тийн гэтлэхийн дөрвөн үүд, хураангуй  
дөрвөн бодь, гурван суртахуун, хоёр чуулган, таван түйтгэр,

гурван нигүүлсэх сэтгэл, дөрвөн цаглашгүй сэтгэл, дөрвөн самади, дөрвөн төрөн түгэхүй, таван мөр, таван эрхтэн, таван хүч, хутагтын найман мөр, арван газар, бурхны дөрвөн лагшин, бурхны гучин хоёр лагшин, наян найраг, зарлигийн жаран гишүүнт эрдэм [Мөн тэнд: 135–145] зэргийг харилцан уялдаа холбоотойгоор шүлэглэн зохиожээ.

«Номгон<sup>1</sup> хан хөвгүүнд илгээсэн зуун найман шүлэгт» хэмээх нэгэн зүйл сургаал бий. Тус сургаал нь ерөнхийдөө бусад сургаалтай адил боловч бусад сургаалаас өвөрмөц өөр санаа нэлээд байна.

«... Урьд урьдын зарлиг журмаа  
Улам хойг хойтод баллаваас  
Албат хэрхэхээ үл мэдэх тул  
Аливаа хуулийг баттай зохиогтун.  
Өтөл цөөхний тул олныг  
Өчүүхний тул их олонхийг  
Одоогийн хэргийн тул ашдын хэргийг  
Огоот доройгуулан бүү үйлдэгтүн» [Номгон хан хөвгүүнд...: 158]  
«... Өөрийг хэт өргөмжлөх хийгээд  
Өнгө эдлэлд үл ханах ба  
Бусдад атаархан уурлах нь  
Буян барагдах гурван шалтгаан.  
Унтах нойронд шунах ба  
....  
Үглэх чалчаа ярианд баясах нь  
Үйл доройтохын гурван шалтгаан мөн.  
Хурьцахад бүхнээс шунах хийгээд  
Ховдоглон архинд дурлах ба  
Өнөд сэрэмжгүй явдал үйлдэх нь  
Өвчин үүсгэх гурван шалтгаан мөн.  
Эрхэм тахих зохистыг үл хүндлэх ба  
Эн сацуу лугаа мөчөөрхөх хийгээд

---

<sup>1</sup> Номгон буюу Номуган (?–1292) нь Хубилай хааны дөтгөөр хөвгүүн. Сурвалжид Бэй Ань ван 北安王 гэж тэмдэглэжээ.



Доордос сэлтийг муушаах нь

Доройтуулж ёс алдахын гурван шалтгаан» [Мөн тэнд: 159]

гэжээ.

Үүнээс гадна «Хөхэчи хан хөвгүүнд увдисласан их, бага хөлгөний номын тайлбар» нэртэй харагчин бич жилийн (1272) таван сард Пагва лам зохиосон сургаалд дөрвөн махбод тэргүүтнээс үүдэх хамаг ертөнцийн орны тогтоц, зургаан зүйл амьтны орших орон газар болсон сав ертөнц, зургаан зүйл зэрэг шимийн амьтан, тэдгээрийн үүсэл, дөрвөн төрөл, тус тусын эдлэх үйлийн зовлон, сайн муу төрөл, тэдгээрийн ялгаа, амьтан гарсан ёс, төрөл авах ёс, үйлийн үр, шүтэн барилдлага, таван цогц, арван найман махбод, зургаан төрөн түгэхүй, эгэл бодгаль, хутагт нарын бага, их хөлгөний суурь, мөр, үрийн номлол зэрэг маш олон тооны онол сургаалийг нэгтгэн хураангуйлж өгүүлсэн бол «Төмөрбух<sup>1</sup> хан хөвгүүнд увдисласан сарны гэрэл» [Төмөрбөх хан хөвгүүнд...: 222–225] хэмээх сургаал шүлэгт гурван аймаг сав, гурван суртахуун, эш, онолын ном, гурван эрдэнэ, ерөөх ба орох бодь сэтгэл, зургаан барамид, дөрвөн хураангуй, таван мөрийн номлолыг товчхон боловч хоорондын уялдаа холбоотойгоор номложээ. «Төгсбух хан хөвгүүнд дөтөд увдисласан рашаан гарах орон» [Төгсбөх хан хөвгүүнд...: 215–222] хэмээх сургаалд арван хар, цагаан үйл, түүний үр боловсрол, зургаан зүйл амьтан ба орчлонгийн жаргал, зовлон зэргийг шүлэглэн зохиожээ.

Энэ мэт Пагва ламаас Их Монголын Юань гүрний хаан, хатан, хан хөвгүүдийн хүсэлт дурдлагаар тэдгээрийн аль хүсэх, аль зохих сургаал номыг айлдан сургаж, Чингим, Мангал, Зэвэгтөмөр, Номгон, Төгсбөх зэрэг хан хөвгүүдэд тусгайлан зориулж, бурхны шашны гүн дэлгэрэнгүй онол номлолыг, төрийг засах ёсны тухай сургаалтай хавсарган, арван буянт

---

<sup>1</sup> Төмөрбух нь Хубилай хааны 7-р хөвгүүн Агругчийн ахмад хөвгүүн юм. Жэнь Ши У Жин ван 镇西武靖王 гэж сурвалжид тэмдэглэжээ.

номын хаант төрийг тэтгэх ба номын гүн гүнзгий утга агуулгыг ертөнцийн аж амьдралын ахуй ёстой холбон номлож, бурхны шашны гүн дэлгэр, нарийн номоор хаан хан хөвгүүдээс эхлээд харц албат хүртэл адилхан сурган зааж байсан байна.

Монголчуудын түүх, соёл, уламжлалд гүн улбаа нөлөө үзүүлсэн бурхны шашны онол номлолын нэгэн илэрхийлэл болсон сургаалийн зохиолууд нэн ялангуяа Монгол оронд Бурхны шашны хоёрдугаар удаагийн их дэлгэрэлтийн үед голлох төлөөлөгч Пагва ламын эдгээр зохиолуудыг улам гүнзгийрүүлэн судлах хэрэгтэй байна.

### Ном зүй

Ардыг тэжээх рашааны дусал нэрт шасдир, түүний тайлбар чанманийн чимэг / CSM. XV боть. II дэвтэр. Улаанбаатар, 1961.

Гунгаажанцан. Субашид. (Цахар гэвш Лувсанцүлтимийн орчуулга ба тайлбар) / Хэвлэлд бэлтгэсэн Ц. Дамдинсүрэн, Д. Дүгэржав. Улаанбаатар, 1958.

Дамдинсүрэн Ц. *Mongyol-un uran jokiyal-un degeji jayun bilig orosibai* / CSM. Tom. XIV. Ulaanbatar, 1959.

Монголын уран зохиолын дээжис. Сайн үгсийн сан / Эмхэтгэсэн Л. Хүрэлбаатар. I боть. Улаанбаатар, 1995.

Монголын уран зохиолын тойм. Хоёрдугаар дэвтэр. (XVII–XVIII зууны үе) / ред. Ц. Дамдинсүрэн, Д. Цэнд. Улаанбаатар, 1976.

Хүрэлбаатар Л. Судар шастирын билиг. Улаанбаатар, 2002.

Хүрэлбаатар Л. Энэтхэг, Төвд, Монголын сургаалийн зохиолын хэлхээ холбоо. (Төвд, монгол эх хэрэглэгдэхүүн, сурвалж бичигт түшиглэсэн судалгаа) *Studia Lingua et Litterarum*. Tom. XVIII. Fasc. 2. Улаанбаатар, 1987.

Цэрэнсодном Д. Монгол уран зохиолын товч түүх. (XIII–XX зууны эхэн) Улаанбаатар, 2002.

Цэрэнсодном Д. Монголын бурханы шашны уран зохиол. Тэргүүн дэвтэр. Улаанбаатар, 1997.

[Алга хан хөвгүүнд илгээсэн захиа]. *rgyal bu al go la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma)*. Vol. IV. P. 353–354.

[Арагч хаан Буман шүлэгт судар бүтээсний буяны бэлгэдэл]. a roq ches (rgyal po al+go cha) 'bum bzhengs pa'i rab byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 459–461.

[Бодьсадва хан хөвгүүнд соёрхсон зарлиг бичиг]. rgyal bu byang chub sems dpa' la gnang ba'i bka' yig. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 351–353.

[Бундари хатны тул зохиосон бүтээлийн зэргийг маш тодотгогч]. dpon mo pun+da ri'i don du mdzad pa bsgrub pa'i rim pa rab tu gsal ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 225–238.

[Дугалдүрми хатанд илгээсэн захиа]. dpon mo du gal dur mis la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 368.

[Зава Дамдин]. 'dzam gling byang phyogs chen po hor gyi rgyal khams kyi rtogs pa brjod pa'i bstan bcos chen po dpyod ldan mgu byed ngo mtshar gser gyi deb ther. Зава Дамдингийн сүмбүмийн «cha» буюу 6-р боть.

[Зэвэг хан хөвгүүнд илгээсэн гурав дахь захиа]. rgyal bu ji big la spring ba. (spring ba gsum pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 367.

[Зэвэг хан хөвгүүнд илгээсэн захиа]. rgyal bu ji big la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 366–367.

[Зэвэг хан хөвгүүнд илгээсэн хоёр дахь захиа]. rgyal bu ji big la spring ba. (spring ba gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 367.

[Зэвэгтөмөр Олонх, Алтангэрэл, Зуун мянгат сэлт судар бүтээсний буяны бэлгэдэл]. ji big de mur gyis phal chen gser 'od stong phrag brgya pa mams bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 454–459.

[Зэвэгтөмөр хан хөвгүүнд илгээсэн захиа]. rgyal bu ji big de mur la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 347–348.

[Зэвэгтөмөр хан хөвгүүнд илгээсэн хоёр дахь захиа]. yang rgyal bu ji big de mur la spring ba. (spring ba gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 348–349.

[Зэвэгтөмөр хан хөвгүүнд соёрхсон өлзий хутгийн шүлэг]. rgyal bu ji big yab yum la gnang ba'i bkra shis kyi tshigs su bcad pa. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume I. P. 315–316.

[Зэвэгтөмөр хан хөвгүүнд увдислан үйлдсэн чандмань эрих]. rgyal bu ji big de mur la gtam du bya ba nor bu'i phreng ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 143–163.

[Мангал хан хөвгүүнд увдислан үйлдсэн өлзий эрих]. rgyal bu mang ga la la gtam du bya ba bkra shis phreng ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 163–184.

[Мангал эцэг эхэд соёрхсон өлзий хутгийн шүлэг]. mang ga la yab yum la gnang ba'i bkra shis. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume I. P. 314–315.

[Мангал эцэг, эх сэлт дэлгэрэнгүй, дунд, хураангуй ба Олонх судар бүтээсний буяны бэлгэдэл]. mang ga la yab yum gyis rgyas 'bring bsdus gsum dang phal po che bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 449–453.

[Номгон хан хөвгүүнд илгээх маш ялгагч зуун найман шүлэгт]. rgyal bu no mo gan la spring ba'i rab tu byed pa. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 185–195.

[Парва]. sa skya gong ma rnam lnga'i gsung 'bum dpe bsdur ma las 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung pot bzhi pa bzhugs. dpal brtsegs bod yig dpe rmying zhib 'jug khang nas bsgrigs. krung go'i bod rig pa dpe skrun khang. Pe cin, 2007.

[Төгсбөх хан хөвгүүнд дөтөд увдисласан рашаан гарах орон хэмээх]. rgyal bu de gus b+ho ga la nye bar gdams pa bdud rtsi'i 'byung gnas. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 215–222.

[Төмөрбөх хан хөвгүүнд увдисласан сарны гэрэл хэмээх]. rgyal bu de mur b+ho ga la gdams pa zla ba'i 'od zer. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 222–225.

[Хаанд увдислах маш ялгагч]. rgyal po la gdams pa'i rab byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 122–129.

[Хайнзунсанбо]. rgya bod mkhas grub rim byon gyi rnam thar phyogs bsgrigs. khetsun sangpo. Library of Tibetan works and archives. Dharamsala. India. 1973–1990.

[Хөхэчи тэргүүтэнд илгээсэн захиа]. ho ko sogs la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 370–371.

[Хөхэчи хан хөвгүүнд увдисласан их, бага хөлгөний номын тайлбар]. rgyal po ho ko la gdams pa. (theg pa che chung gi chos kyi nam gzhaq) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 195–215.

[Хубилай хаан Дэлгэрэнгүй, дунд, хураангуй судар бүтээсний буяны бэлгэдэл]. go pe las rgyas 'bring bsdus gsum bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 461–464.

[Хубилай хаан, хөвгүүд, хатан сэлтэд амар амгалан үйлдэх өлзий хутгийн шүлэглэл цог төгөлдөр хэмээх]. rgyal po go pe la sras dang btsun mor bcas la de legs su bya ba'i bkra shis tshigs su bcad pa las yos dpal ldan ma. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 600–601.

[Чингим хан хөвгүүнд илгээсэн гурав дахь захиа]. yang jim gyim la spring ba (spring yig gsum pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 241–242.

[Чингим хан хөвгүүнд илгээсэн захиа]. rgyal bu jim gyim la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 369–370.

[Чингим хан хөвгүүнд илгээсэн захиа]. rgyal sras jim gyim la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 238–239.

[Чингим хан хөвгүүнд илгээсэн хоёр дахь захиа]. yang jim gyim la spring ba (spring yig gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 239–241.

[Чингим хан хөвгүүнд номын хүрд эргүүлсний зурхай]. rgyal bu jim gyim gyis chos 'khor bskor ba'i rtsis. (dus chen gyi skor) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 427–428.

## References

Ardyг tezhеekh rashaany dusal nert shasdir, tuunii tailbar chanmaniin chimeg / CSM. XV bot'. II devter. Ulaanbaatar, 1961.

Gungaazhantsan. Subashid. (Tsakhar gevsh Luvsantsultimiin orchuulga ba tailbar) / Khevleld beltgesen Ts. Damdinsuren, D. Dugerzhav. Ulaanbaatar, 1958.

Damdinsuren Ts. Monggol-un uran jokiyal-un degeji jagun bilig orosi-bai / CSM, Tom. XIV. Ulaanbaatar, 1959.

Mongolyn uran zokhiolyn deezhis. Sain ugsiin san / Emkhetgesen L. Khurelbaatar. I bot'. Ulaanbaatar, 1995.

Mongolyn uran zokhiolyn toim. Khoerdugaar devter. (XVII–XVIII zuuny ue) / red. Ts. Damdinsuren, D. Tsend. Ulaanbaatar, 1976.

Khurelbaatar L. Sudar shastiry bilig. Ulaanbaatar, 2002.

Khurelbaatar L. Enetkheg, Tovd, Mongolyn surgaaliin zokhiolyn khelkhee kholboo. (Tovd, mongol ekh khereglegdekhуun, survalzh bichigt tushiglesen sudalgaa) Studia Lingua et Litterarum. Tom. XVIII. Fasc. 2. Ulaanbaatar, 1987.

Tserensodnom D. Mongol uran zokhiolyn товч туух. (XIII–XX зууны екhen) Ulaanbaatar, 2002.

Tserensodnom D. Mongolyn burkhany shashny uran zokhiol. Tergуun devter. Ulaanbaatar, 1997.

[Alga khan khovguund ilgeesen zakhia]. rgyal bu al go la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 353–354.

[Aragch khaan Buman shulegt sudar buteesnii buiany belgedel]. a rog ches (rgyal po al+go cha) 'bum bzhengs pa'i rab byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 459–461.

[Bod'sadva khan khovguund soerkhson zarlig bichig]. rgyal bu byang chub sems dpa' la gnang ba'i bka' yig. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 351–353.

[Bundari khatny tul zokhioson buteeliin zergiig mash todotgogch]. dpon mo pun+da ri'i don du mdzad pa bsgrub pa'i rim pa rab tu gsal ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 225–238.

[Dugaldurmi khatand ilgeesen zakhia]. dpon mo du gal dur mis la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 368.

[Zava Damdin]. 'dzam gling byang phyogs chen po hor gyi rgyal khams kyi rtogs pa brjod pa'i bstan bcos chen po dpyod ldan mgu byed ngo mtshar gser gyi deb ther. Zava Damdingiin sumbumiin «cha» buiuu 6-r bot'.

[Zeveg khan khovguund ilgeesen gurav dakh' zakhia]. rgyal bu ji big la spring ba. (spring ba gsum pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 367.

[Zeveg khan khovguund ilgeesen zakhia]. rgyal bu ji big la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 366–367.

[Zeveg khan khovguund ilgeesen khoer dakh' zakhia]. rgyal bu ji big la spring ba. (spring ba gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 367.

[Zevetomor Olonkh, Altangerel, Zuun miangat selt sudar buteesnii buiany belgedel]. ji big de mur gyis phal chen gser 'od stong phrag brgya pa rnams bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 454–459.

[Zevetomor khan khovguund ilgeesen zakhia]. rgyal bu ji big de mur la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 347–348.

[Zevetomor khan khovguund ilgeesen khoer dakh' zakhia]. yang rgyal bu ji big de mur la spring ba. (spring ba gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 348–349.

[Zevetomor khan khovguund soerkhson olzii khutgiin shuleg]. rgyal bu ji big yab yum la gnang ba'i bkra shis kyi tshigs su bcad pa. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume I. P. 315–316.

[Zevetomor khan khovguund uvdislán uildsen chandman' erikh]. rgyal bu ji big de mur la gtam du bya ba nor bu'i phreng ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 143–163.

[Mangal khan khovguund uvdislán uildsen olzii erikh]. rgyal bu mang ga la la gtam du bya ba bkra shis phreng ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 163–184.

[Mangal etseg ekhed soerkhson olzii khutgiin shuleg]. mang ga la yab yum la gnang ba'i bkra shis. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume I. P. 314–315.

[Mangal etseg, ekh selt delgerengui, dund, khuraangui ba Olonkh sudar buteesnii buiany belgedel]. mang ga la yab yum gyis rgyas 'bring bsdus gsum dang phal po che bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. R. 449–453.

[Nomgon khan khovguund ilgeekh mash ialgagch zuun naiman shulegt]. rgyal bu no mo gan la spring ba'i rab tu byed pa. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 185–195.

[Pagva]. sa skya gong ma rnam lnga'i gsung 'bum dpe bsdur ma las 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung pot bzhi pa bzhugs. dpal brtsegs bod yig dpe rnying zhib 'jug khang nas bsgrigs. krung go'i bod rig pa dpe skrun khang. Re cin, 2007.

[Togsbokh khan khovguund dotod uvdislisan rashaan garakh oron khemeekh]. rgyal bu de gus b+ho ga la nye bar gdams pa bdud rtsi'i 'byung gnas. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 215–222.

[Tomorbokh khan khovguund uvdislisan sarny gerel khemeekh]. rgyal bu de mur b+ho ga la gdams pa zla ba'i 'od zer. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Volume IV. P. 222–225.

[Khaand uvdislakh mash ialgagch]. rgyal po la gdams pa'i rab byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 122–129.

[Khainzunsanbo]. rgya bod mkhas grub rim byon gyi rnam thar phyogs bsgrigs. khetsun sangpo. Library of Tibetan works and archives. Dharamsala. India. 1973–1990.

[Khokhechi terguutend ilgeesen zakhia]. ho ko sogs la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 370–371.

[Khokhechi khan khovguund uvdislisan ikh, бага kholgonii nomyn tailbar]. rgyal po ho ko la gdams pa. (theg pa che chung gi chos kyi rnam gzhag) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 195–215.

[Khubilai khaan Delgerengui, dund, khuraangui sudar buteesnii buiany belgedel]. go pe las rgyas 'bring bsdus gsum bzhengs pa'i mtshon byed. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 461–464.

[Khubilai khaan, khovguud, khatan selted amar amgalan uildekh olzii khutgiin shuleglel tsog togoldor khemeekh]. rgyal po go pe la sras dang btsun mor bcas la de legs su bya ba'i bkra shis tshigs su bcad pa las yos dpal ldan ma. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 600–601.



[Chingim khan khovguund ilgeesen gurav dakh' zakhia]. yang jim gyim la spring ba (spring yig gsum pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vo. IV. P. 241–242.

[Chingim khan khovguund ilgeesen zakhia]. rgyal bu jim gyim la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 369–370.

[Chingim khan khovguund ilgeesen zakhia]. rgyal sras jim gyim la spring ba. 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol.IV. P. 238–239.

[Chingim khan khovguund ilgeesen khoer dakh' zakhia]. yang jim gyim la spring ba (spring yig gnyis pa) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol.IV. P. 239–241.

[Chingim khan khovguund nomyn khurd erguulsanii zurkhai]. rgyal bu jim gyim gyis chos 'khor bskor ba'i rtsis. (dus chen gyi skor) 'gro mgon chos rgyal 'phags pa'i gsung 'bum (dpe bsdur ma). Vol. IV. P. 427–428.

## СВЕДЕНИЯ ОБ АВТОРАХ

БАДЛАЕВА Татьяна Владимировна – кандидат исторических наук, библиотекарь Центра восточных рукописей и ксилографов ИМБТ СО РАН. E-mail: t.badlaeva@mail.ru

БУРАЕВА Светлана Валерьевна – доктор исторических наук, ведущий научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: ladys@inbox.ru

ДАШИБАЛОВА Дарима Владимировна – кандидат филологических наук, старший научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: dardash3@gmail.com

ЖАБОН Юмжана Жалсановна – кандидат исторических наук, старший научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: yumzhan@mail.ru

КАМАЛОВ Аблет Каюмович – профессор Университета «Туран», Алматы, Казахстан. E-mail: a.kamalov@turan-edu.kz

ЛЕПЕХОВ Сергей Юрьевич - доктор философских наук, главный научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: lepekhov@yandex.ru

МЯГМАРСУРЭН Гомбордж – доктор наук, директор Института изучения буддийской культуры при монастыре Зуун-Хурээ Дашчойлин. E-mail: lamamiga@yahoo.com

РИНЧИНОВ Олег Сергеевич – кандидат физико-математических наук, ведущий научный сотрудник Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: orinch2@mail.ru

ХАРТАЕВ Владимир Владиславович – младший научный сотрудник лаборатории «Центр переводов с восточных языков» Института монголоведения, буддологии и тибетологии СО РАН. E-mail: buda2004@mail.ru

## Содержание

### **РЕЛИГИЯ, ЭТНОГРАФИЯ И КУЛЬТУРА**

<i>Лепехов С. Ю.</i> Концепция иллюзорности мира в «Ратна-гуна-самчая-гатхе» .....	3
<i>Хартаев В. В.</i> Специфика тибетской исторической литературы жанра чойчжун.....	32
<i>Мягмарсүрэн Г.</i> Пагба-лама Лодойжанцан и его поучения .....	46
<i>Жабон Ю. Ж.</i> Тибетские источники о личностных качествах обучающихся медицине.....	69

### **ИСТОРИЯ, КУЛЬТУРА И ЛИТЕРАТУРА**

<i>Дашибалова Д. В.</i> К вопросу об архитектонике исторических новелл Б. Ринчена.....	82
<i>Бадлаева Т. В.</i> Организация научной библиотеки Бурятского Ученого Комитета (1920-е гг.) .....	91

### **ИСТОЧНИКОВЕДЕНИЕ, АРХИВОВЕДЕНИЕ, КОДИКОЛОГИЯ**

<i>Камалов А. К.</i> Вопросы социальной истории Восточного Туркестана в полевых материалах руководителя Первой Русской Туркестанской экспедиции академика С. Ф. Ольденбурга (1909–1910 гг.).....	105
<i>Бураева С. В.</i> Фотохроника научной жизни Бурятского института общественных наук в 1970–1980-е гг. (по материалам общего архивного фонда ЦВРК).....	128
<i>Ринчинов О. С.</i> Современные направления мультидисциплинарного изучения буддийского книжного наследия.....	143
<i>Сведения об авторах</i> .....	154